

# ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Б. Уламбаяр

2023 оны 1 дүгээр улирал



## МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Баянсангийн Уламбаяр миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: 2023 оны 1 дүгээр улирал (“Тайлант хугацаа”).

### 1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

*1/01~3/13-ний хугацааны хурлуудын хувьд, явцын тайланг бэлтгэж тусад нь 1/23, 2/02, 3/06, 3/23-ны өдрүүдэд МонголБанканд хүргүүлсэн тул, энэ тайланд агуулгыг нь давхардуулж тайлагнаагүй болно.*

#### Хамрах хугацаан дахь ТУЗ-ийн хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	2023.01.09 2023.01.11 2023.02.16 2023.02.23 2023.03.03
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал	Даргаар	2023.02.23
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны хурал	Ажиглагчаар	2023.02.23
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр/Ажиглагчаар	2023.02.02
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны ээлжит хурал	Даргаар	2023//03/14
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурал	Гишүүнээр	2023/03/14
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны ээлжит хурал	Ажиглагчаар	2023/03/14
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал	Хараат бус гишүүнээр	2023/03/27

### ТУЗ-ийн Аудитын хорооны ээлжит хурал

ТУЗ-ийн хорооны ээлжит хурал 2023/03/14-ий өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Шийдвэр</b>
1	Дотоод аудит шалгалтын тайлан 1.1. Үйл ажиллагааны эрсдэл 1.2. ЖДҮ эрсдэлийн анализ 1.3. Цахим банк	Танилцуулж, хэлэлцсэн.
2	Хамаарал бүхийн этгээдүүдийн улирлын тайлан (Монголбанкны журмын дагуу)	Танилцуулж, хэлэлцсэн.
3	СОВИТ дээр суурилсан ИТ хөндлөнгийн аудит шалгалт (Монголбанкны шаардлагын дагуу)	Танилцуулж, хэлэлцсэн.

- ТУЗ-ийн Аудитын хорооны хурлыг, Аудитын хорооны даргын хувьд миний бие удирдаж явуулсан.
  - Хурлын өмнө, зарим асуудлуудын талаар Ерөнхий аудитортой ярилцаж тодруулга авсан.
- Дотоод аудит шалгалтын ажлын ерөнхий хүрээнд, менежментийн талтай ерөнхий чиглэлийн талаар санал солилцох, мөн аудитын ажлын зохион байгуулалтын талаар цаашид илүү үр дүнтэйгээр сайжруулах боломж бий эсэх талаар санал гарсан бөгөөд энэ талаар Аудитын хорооны дарга, ерөнхий аудитортой судлахаар болсон.
- Дээрх асуудал (2) дээр, тодорхой этгээдүүдийн мэдээллийг Ерөнхий аудитор авч чадахгүй байгаа тул, харилцаа холбооны талаас нь шаардлагатай бол аудитын хорооны даргын хувиар дээр дэмжлэг үзүүлэхээр болсон.

### ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурал

ТУЗ-ийн хорооны ээлжит хурал 2023/03/14-ий өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Шийдвэр</b>
1	2023 оны 1 сарын Эрсдэлийн тайлан	Танилцуулж, хэлэлцсэн.
2	Монголбанкны шинэчилсэн журмын дагуу 2023 оны нөхөн сэргээх төлөвлөгөө	ТУЗ-еер батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн.
3	2023 оны 1 сарын Хянан нийцүүлэлтийн тайлан, ОХУ-ын эсрэг тавигдсан олон улсын хорионы нөлөөны нөхцөл байдал	Танилцуулж, хэлэлцсэн.
4	Нэгдмэл сонирхолтой этгээд/Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах	ТУЗ-еер батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн.

- Дээрх асуудал (2) дээр миний зүгээс, системийн эрсдэл үүсэх 3-р сценарийн хувьд, ажилгүйдлийн түвшин 18% болох гэсэн суурь параметр нь хир бодитой талаар, мөн ер нь одоогийн Монгол улсын ажилгүйдлийн түвшин ба холбогдох датаг

нарийвчлалтай авч болох эсэх, ашиглаж болох эсэх талаар саналаа хэлж, хэлэлцүүлсэн.

- Асуудал (2), (4)-ийг хорооны гишүүд санал нэгтэй баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

### ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны ээлжит хурал

ТУЗ-ийн хорооны ээлжит хурал 2023/03/14-ий өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр
1	IPO хуваарилалтанд ажилчдыг оролцуулах	ТУЗ-өөр батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн.
2	Гүйцэтгэх захирлын гэрээний сунгалт	ТУЗ-өөр батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн.
3	ТУЗ-ийн даргын гэрээний сунгалт	ТУЗ-өөр батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн.
4	ТУЗ болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ (Монголбанкны шаардлагын дагуу)	Танилцуулж, хэлэлцсэн.

- ТУЗ-ийн Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны хуралд ажиглагчаар оролцсон.
- Дээрх асуудал (1) дээр миний зүгээс, ажилчдын худалдаж авах хувьцааны lockup хугацааны талаар тодруулж хэлэлцсэн. Мөн дотоодын зах зээл дээр бусад банкууд IPO дээрээ, ажилчдаа зориулж төстэй програм нэвтрүүлсэн талаар, тэр нь үр дүнтэй байгаа талаар тэмдэглэж хэлсэн. Энэ нь маркетинг, PR талаасаа ч эерэг имиж үүсгэх давуу талтайг онцолсон.
- Дээрх асуудал (2) дээр миний зүгээс, өмнөх хугацааны гэрээнүүдийн талаар лавлаж тодруулсан. Мөн ХХОАТ тооцоолол талаас нь тодруулсан.
- Дээрх асуудал (3) дээр миний зүгээс, зарим нөхцөлүүдийг тодруулж асууж, хэлэлцүүлэгт оролцсон.

### ТУЗ-ийн хурал

ТУЗ-ийн ээлжит хурал 2023/03/14, 15-ий өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр
1	<b>ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:</b> 1.1 Эрсдэлийн Удирдлагын хороо: (a) Монголбанкны шинэчилсэн журмын дагуу 2023 оны нөхөн сэргээх төлөвлөгөө; (b) Нэгдмэл сонирхолтой этгээд/Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах.	ТУЗ-өөр батлуулахаар санал болгож шийдвэрлэсэн ТУЗ-ийн Хороодын асуудлуудыг ТУЗ-өөр баталсан.
2	IPO хийхтэй холбогдуулан гадны хуулийн зөвлөхийн санал, дүгнэлт	Танилцуулж, хэлэлцсэн
3	ХасБанкны ногдол ашгийн бодлого	Батлагдсан.

4	Андеррайтеруудын хараат бус хяналтын захидал	Хэлэлцсэн
5	IPO үнэ (үнэлгээ) & БДО тайлан	Батлагдсан.
6	IPO хуваарилалт (Стратегийн ба жижиглэн худалдаа)	Батлагдсан.
7	IPO танилцуулга	Батлагдсан.
8	Өргөдлийн маягтууд (IPO танилцуулгын хавсралт)	Батлагдсан.
9	Банкны үйл ажиллагааны явцын 2023 оны 1 сарын тайлан	Танилцуулж, хэлэлцсэн
10	IT тайлан	Танилцуулж, хэлэлцсэн

- (5) асуудал дээр миний зүгээс, өмнөх удаагийн Банкны үнэлгээтэй харьцуулахад энэ удаад өөрөөр хэрэглэгдсэн суурь параметруудийг лавлаж, тодруулга авсан. Мөн Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлтийн хэмжээг тодруулсан. IPO үнийн талаар ч хэлэлцүүлэгт өөрийн саналаа нэмэрлэж, эцсийн шийдвэр гаргахад идэвхитэй оролцсон.
- (7) асуудал дээр миний зүгээс, Банкны хуучин хамаарал бүхий үнэт цаасны компанийн underwriting үйл ажиллагаан дахь оролцооны талаар тодруулга авсан.
- (10) асуудал дээр миний зүгээс, \*\*\* цахим үйлчилгээний талаар лавлаж, тодруулсан.  
Мөн шинээр нэвтрүүлэхээр хөгжүүлэх шатандаа ажиллаж байгаа В\*\*\* үйлчилгээний талаар, Банк өөрсдөө хэрэгжүүлэх эсвэл мерчантуудтай хамтрах эсэх тухай тодруулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.
- (3), (5), (6), (7), (8) асуудлыг ТУЗ-ийн гишүүд баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

### ТУЗ-ийн урт хугацааны стратегийн уулзалт

Тус уулзалт 2023/03/15-ий өдөр болж, ТУЗ-ийн гишүүд болон менежментийн баг хамтдаа Банкны урт хугацааны буюу 5 жилийн стратеги болон холбогдох санхүүгийн төсөөллийн тухай бэлтгэсэн материалтай танилцаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Тус материалын нэг хэсэг нь мөн IPO-той холбогдох Банкны үнэлгээ зэрэгт хэрэглэгдэх чухал агуулга байсан.

- Миний зүгээс хэлэлцүүлэгт идэвхитэй оролцсон. \*\*\* компанитай хамтрах боломжийн стратегийн тухай тодруулж хэлэлцүүлэг өрнүүлэн, мөн 5 жилийн санхүүгийн төсөөллийн тал дээр саналаа нэмэрлэсэн.

Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах цахим санал хураалтын хурлуудад оролцсон.

### Хамрах хугацаан дахь цахим санал хураалтын хурлууд

#### Хүснэгт 2

Хурлууд	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны цахим санал хураалтын хурал	Банкны зээлийн хорооны эрхийг давсан, харилцагч Т** компанийн зээлийн хүсэлт	2023/01/17
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны цахим санал	Банкны зээлийн хорооны эрхийг давсан, харилцагч С** компанийн	2023/02/28

## 2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

**(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)**

*БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.*

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурлаар 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл батлагдсан бөгөөд эдгээр бүх санал хураалтанд оролцож, дэмжсэн санал өгч ажилласан. (Дээрх 2023/03/14-ний Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын мэдээнд мөн тэмдэглэсэн)

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

## 3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

**(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)**

*Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.*

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
<b>КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5</b> <b>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)</b>	Уг заалтын дагуу, хяналтыг тавьж зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавин, бүх хурлуудад оролцож шийдвэрүүдээ гаргасан. Тайлангийн хугацаанд, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэрүүд нь уг заалтанд тодорхойлогдохуйц сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно.  Энэ талаар, тайлан дахь оролцсон хурал тус бүрийн тайлбарт шаардлагатай бол тэмдэглэсэн.
<b>КтХ 79.3.2</b>	Уг заалтын хүрээнд, гүйцэтгэх удирдлага нь ил тод, нээлттэй байдлыг үргэлжлүүлэн хэвийн хангаж ажиллаж байгаа бөгөөд, тусгайчлан

<b>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)</b>	<p>үүрэг өгч ажиллахаар нөхцөл байдал үүсээгүй болно.</p>
<b>КтХ 79.3.3</b>  <b>(ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГУУЛАХ)</b>	<p><b>2023/03/27</b> өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан.</p> <p>Банкны IPO хийх бэлтгэл ажлын хүрээнд, бүтцийн өөрчлөн байгуулалттай холбоотой асуудлуудыг хэлэлцсэн.</p> <p>Хурлаар хэлэлцсэн аливаа асуудалд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй болно.</p>
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1</b>  <b>(ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)</b>	<p>Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна.</p> <p>ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.</p>
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2</b>  <b>(ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)</b>	<p>Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.</p>
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3</b>  <b>(БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)</b>	<p>ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.</p>
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6</b>  <b>(МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)</b>	<p>Тэмдэглэхүйц зүйл гараагүй.</p>

## 4. БУСАД

- 2023/01/21 Банкны 2022 оны үр дүнгийн тайлангийн бүх ажилчдын хуралд биеэр оролцсон.
- 2023/02/03 ТУЗ-ийн Аудитын хорооны даргын хувиар, Ерөнхий аудиторын 2022 оны ажлын үр дүн, KPI-г дүгнэсэн.
- 2023/03/16 Хараат бус гишүүд хамтаар МонголБанкны холбогдох удирдлага, хяналт шалгалтын газрын төлөөлөгчидтэй хийсэн албан уулзалтанд оролцсон.
- 2023/03/15 ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээг гүйцэтгэж ТУЗ-ийн нарийн бичигт өгсөн.
- 2023/03/28 ТУЗ-ийн өөрийн үнэлгээний тайланг бэлтгэж ТУЗ-ийн нарийн бичигт өгсөн.

Хүндэтгэсэн,



**Б. Уламбаяр**

**ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн**